



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/64

Чингис хот

Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дүгээр заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 аймгийн Онцгой комиссын №03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын голомт үүсээгүй, эрүүл бүс байгаатай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудыг /ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгээс бусад/ хэвийн горимд ажиллуулсугай.

2. Ерөнхий боловсролын 1, 2, 5, 9 дүгээр ангийн сурагчдын давтлагыг эцэг эхийн сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс танхимын давтлагыг эхлүүлэх, давтлага эхлүүлэхтэй холбогдуулан хүүхдийн бүртгэл, сургалтын цагийн хуваарь, анги тэнхимийн бэлтгэл ажлыг хангуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

3. Төрийн байгууллагуудын 0-12 насны хүүхэдтэй эхчүүдэд /ганц бие эцэг/ гэрээс ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг тооцож олгохыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Хүнс тээвэрлэлт хийх зөвшөөрөл, QR код авсан хувь хүн болон хуулийн этгээдүүд үнийн хөөрөгдөл үүсгэж болзошгүй байгаатай холбогдуулан хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Хэнтий аймгийн хэмжээнд 2021 оны 2 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 10:00-19:00 цаг хүртэл архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулахыг /баар, караоке, цэнгээний газраас бусад/ аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрч, цагийн хязгаарлалтад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Б.Батсайхан/, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

231010199

6. Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, дархлааг дэмжих зорилгоор спорт заалны үйл ажиллагааг 18 дээш насны /секц дугуйлан хамаарахгүй/ 15 хүнээс ихгүйгээр 2 цагийн хугацаатай зохицуулалт хийхийг Биеийн тамир, спортын газар /Г.Нэргүйбаатар/, Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хангуулан хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

7. Монгол Улсын Засгийн газрын 2021 онь 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/59 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулж иргэдэд уриалж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Баяр амралтын өдрүүдэд сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хүч хэрэгслийг томилгоожуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн 2021 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 15:00 цагийн дотор ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

9. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 11 сарын 30-ны өдрийн А/544 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чөгсомжав/, Шуурхай штаб /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ